

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Рашаант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/143/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Хөвсгөл аймаг
2022 он

Хөвсгөл аймаг Төрийн Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn
Аудитор: Л.Мандахнаран
Утас: 92118277 Цахим хаяг: MandakhnaranL@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	7
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	8
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	11
4.1 ЕРӨНХИЙ ЗҮЙЛ.....	15
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.5.1 Завсрын аудитын талаар.....	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
5.1 Төлбөрийн акт.....	17
5.2 Албан шаардлага.....	17
5.3 Зөвлөмж.....	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ИТХТ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
ТББ	Төрийн бус байгууллага
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120

Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn

2023.03.27 № 01/301
танай _____-ны № _____-т

РАШААНТ СУМЫН ТӨСВИЙН
ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ
Б.АЛТАНГЭРЭЛ ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Рашаант сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Рашаант сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих байгууллагын санхүүгийн тайланг орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлангаас улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд шилжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Орон нутгийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг нэр төрөл бүрээр авч үзвэл 9 төрлийн орлогын нийт 24.1 сая төгрөгийг орлогын төлөвлөгөө тасарсан байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Рашаант сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Хөвсгөл аймгийн Засаг даргаар батлуулан ажиллаж, хэрэгжилтийг 87.0 хувиар дүгнүүлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу

илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	900,408.7	344,653.5
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	234,064.9	170,229.2
33	АВЛАГА	142,660.3	73,157.2
34	УРЬДЧИЛГАА	0.0	0.0
35	БАРАА МАТЕРИАЛ	523,683.5	101,267.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	8,309,437.6	1,379,254.1
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	58,514.2	100,000.0
37300	Урт хугацаат зээл	58,514.2	100,000.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	8,250,923.5	1,279,254.1
39100	Газар	0.0	0.0
39200	Биет хөрөнгө	8,053,787.6	1,202,866.2
39300	Биет бус хөрөнгө	197,135.9	76,387.9
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	9,209,846.3	1,723,907.5
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	96,471.3	0.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	96,471.3	0.0
41300	Өглөг	96,471.3	0.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	9,113,375.0	1,723,907.5
51	Засгийн газрын хувь оролцоо	9,113,375.0	1,723,907.5
51100	Засгийн газрын оруулсан капитал	2,554,709.7	473,097.3
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	2,554,709.7	473,097.3
51200	Хуримтлагдсан үр дүн	4,710,773.2	1,125,544.2
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,847,892.0	125,266.0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	9,209,846.3	1,723,907.5

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5,375,840.8	1,623,063.8
11	ТАТВАРЫН ОРЛОГО	205,924.3	383,268.5
110	Орлогын албан татвар	66,981.9	223,591.9
1100	Хувь хүний орлогын албан татвар	66,981.9	241,891.9
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0.0	-18,300.0
113	Хөрөнгийн албан татвар	55,144.4	80,545.5
118	Бусад татвар, төлбөр, хураамж	83,798.1	79,131.1
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,089,750.2	394,266.0
120	Нийтлэг татварын бус орлого	1,089,750.2	394,266.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,080,166.2	845,529.2
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,674,642.0	1,200,595.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,674,642.0	1,200,595.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,614,488.2	1,172,864.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,852,880.8	372,789.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	249,017.0	46,133.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	461,614.9	484,936.6
2104	Хангамж, бараа материалын зардал	127,245.5	50,237.0
2105	Нормативт зардал	407,049.3	628.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	36,929.9	26,411.6
2107	Томилолт, зочны зардал	2,288.7	807.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	46,612.4	39,429.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	430,849.7	151,491.0
211	ХҮҮ	0.0	0.0

212	ТАТААС	0.0	0.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,060,153.8	27,731.1
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	0.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	701,198.7	422,468.2
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	125,332.2	7,827,372.0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	575,866.5	-7,404,903.8

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,347,120.6	1,293,992.1
11	ТАТВАРЫН ОРЛОГО	205,924.3	383,268.5
110	Орлогын албан татвар	66,981.9	223,591.9
1100	Хувь хүний орлогын албан татвар	66,981.9	241,891.9
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0.0	-18,300.0
113	Хөрөнгийн албан татвар	55,144.4	80,545.5
118	Бусад татвар, төлбөр, хураамж	83,798.1	79,131.1
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	13,168.9	13,956.7
1181	Газрын төлбөр	4,751.4	13,450.9
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	65,877.9	51,723.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	118,473.8	65,194.3
120	Нийтлэг татварын бус орлого	118,473.8	65,194.3
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,022,722.4	845,529.2
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,031,702.2	1,255,267.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,031,702.2	1,255,267.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,966,982.7	1,026,840.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,852,880.8	372,789.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	249,017.0	46,133.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	438,957.2	484,686.6
2104	Хангамж, бараа материалын зардал	97,621.5	40,853.0
2105	Нормативт зардал	184,140.2	628.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	51,761.9	24,541.6
2107	Томилолт, зочны зардал	2,288.7	807.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	52,900.2	42,879.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	37,415.4	13,521.4
211	ХҮҮ	0.0	0.0
212	ТАТААС	0.0	0.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,064,719.5	228,426.9
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	315,418.4	38,724.4
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	130,902.6	2,560.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	130,902.6	2,560.0
2200	Дотоод эх үүсвэрээр	130,902.6	2,560.0
2260	Гадаад эх үүсвэрээр	0.0	0.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-130,902.6	-2,560.0
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.0	-100,000.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0.0	100,000.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	184,515.8	-63,835.6
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	49,549.1	234,064.9
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	234,064.9	170,229.2

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,537,508.4	8,537,508.4
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	360.8	360.8
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	8,537,869.2	8,537,869.2
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-360.8	-360.8
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0
7	Өмчид гарсан өөрчлөлт	0.0	0.0
8	Зарласан ногдол ашиг	0.0	0.0
9	Тайлант үеийн үр дүн	575,866.5	575,866.5
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,113,375.0	9,113,375.0
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	9,113,375.0	9,113,375.0
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	15,436.4	15,436.4
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	9,128,811.4	9,128,811.4
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0
17	Өмчид гарсан өөрчилөлт	0.0	0.0
18	Зарласан ногдол ашиг	0.0	0.0
19	Тайлант үеийн үр дүн	-7,404,903.8	-7,404,903.8
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,723,907.5	1,723,907.5

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,464,175.60	1,334,329.47	129,846.13
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,295,700.30	1,234,329.47	61,370.83
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,016,642.60	1,007,638.53	9,004.07
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	376,257.30	372,789.00	3,468.30
210101	Үндсэн цалин	322,432.60	299,116.92	23,315.68
210102	Нэмэгдэл	50,445.90	49,517.48	928.42
210104	Урамшуулал	3,378.80	24,154.60	-20,775.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	47,452.50	46,133.58	1,318.92
210201	Тэтгэврийн даатгал	31,885.70	31,311.83	573.87
210202	Тэтгэмжийн даатгал	4,215.70	3,937.68	278.02
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,033.70	2,979.40	54.30
210204	Ажилгүйдлийн даатгал	756.30	830.92	-74.62
210205	Эрүүл мэндийн даатгал	7,561.10	7,073.76	487.34
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	484,381.10	481,513.77	2,867.33
210301	Гэрэл, цахилгаан	25,940.00	25,561.78	378.22
210302	Түлш, халаалт	450,221.10	450,060.04	161.06
210303	Цэвэр, бохир ус	8,220.00	5,891.95	2,328.05
2104	Хангамж, бараа материалын зардал	32,217.00	31,983.00	234.00
210401	Бичиг хэрэг	4,045.00	4,045.00	0.00
210402	Тээвэр, шатахуун	18,776.00	18,776.00	0.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,140.00	4,906.00	234.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,056.00	3,056.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,200.00	1,200.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24,416.60	24,416.60	0.00
210602	Тавилга	1,500.00	1,500.00	0.00

210604	Урсгал засвар	22,916.60	22,916.60	0.00
2107	Томилолт, зочны зардал	807.70	807.70	0.00
210702	Дотоод албан томилолт	807.70	807.70	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	44,552.60	43,437.09	1,115.51
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	43,274.90	42,227.30	1,047.60
210803	Даатгалын үйлчилгээ	151.00	150.98	0.03
210804	Тээврийн хэрэгслийн татвар	156.60	156.60	0.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	34.00	33.94	0.06
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	374.00	374.00	0.00
210807	Газрын төлбөр	562.10	494.28	67.82
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,557.80	6,557.80	0.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,000.00	3,000.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,557.80	3,557.80	0.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	279,057.70	226,690.94	52,366.77
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	253,017.10	200,695.80	52,321.30
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	253,017.10	200,695.80	52,321.30
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	0.00	0	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	26,040.60	25,995.14	45.47
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	21,730.20	21,730.20	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,310.40	4,264.94	45.46
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	168,475.30	100,000.00	68,475.30
230001	Эргэж төлөгдөх зээл	168,475.30	100,000.00	68,475.30
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,464,175.60	1,330,037.43	134,138.17
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	126,854.30	209,107.60	-82,253.30
310001	Улсын төсвөөс санхүүжих	0.00	0	0.00
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	126,854.30	209,107.60	-82,253.30
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,068,511.50	1,066,218.74	2,292.76
320001	Орон нутгийн төсвөөс	1,068,511.50	1,066,218.74	2,292.76
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	268,809.80	54,711.08	214,098.72
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	59,518.60	50,148.36	9,370.24
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,219.20	4,562.72	-1,343.52
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	206,072.00	0	206,072.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	152,455.04	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	136,260.46	

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	16,534.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	16,534.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	14,798.70
210205	Эрүүл мэндийн даатгал	0.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,172.80
210301	Гэрэл, цахилгаан	1,795.80
210303	Цэвэр, бохир ус	1,377.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,870.00
210401	Бичиг хэрэг	606.00
210402	Тээвэр, шатахуун	7,543.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	30.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	691.00
2105	Нормативт зардал	628.40

Рашаант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.00
210502	Хоол, хүнс	628.40
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,625.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,075.00
210604	Урсгал засвар	550.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	502.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	502.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,736.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	0.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,736.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,736.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	16,534.70
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	16,534.70
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,471.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,563.70
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар: Рашаант сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь стратегийн төлөвлөгөө, бодлогын удирдамжийн хэрэгжилт, хөтөлбөр, төслийн биелэлт зэргийг Засаг даргын дэргэдэх тасаг, алба, албан байгууллага, аж ахуйн нэгжид хэрхэн хэрэгжиж байгааг хянах, шалгах, зохицуулах, чиглэл өгөх, мэдээлэл авах зэрэг эрхтэйгээс гадна дээрх байгууллагаар дамжуулан мэдээллийг цуглуулж хяналт шинжилгээ хийх дүгнэлт гаргах үүрэгтэй ажилладаг орон нутгийн төсвийн захирагч юм.

Хөвсгөл аймгийн Рашаант сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь “Төсвийн ил тод байдлыг хангаж, төсвийг үр ашигтай зарцуулж, төсвийн хэтрэлтгүй, хэмнэлттэй ажиллах” зорилгыг дэвшүүлэн ажилласан байна.

Тус сумын Засаг дарга нь нь аймгийн Засаг даргаар 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө батлуулан ажиллаж, хэрэгжилтийг 87.0 хувьтай биелүүлж ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар: Төсвийн төвлөрүүлэн захирагч нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй. Тус төвлөрүүлэн захирагчийн харьяанд байгаа байгууллагууд нь Төсвийн тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн удирдлагын тухай хууль, Татварын багц хууль болон бусад хууль тогтоомж, журам зааврыг мөрдөн ажилласан байна.

Тус төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд нийт 2 байгууллага, орон нутгийн 2 сан, Ерөнхий орлогын данс, Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн хаалтын санхүүгийн тайланг нэгтгэсэн байна. Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 403 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Боловсролын ерөнхий газрыг байгуулжээ. Засгийн газрын 2022 оны 131 дүгээр тогтоолоор Боловсролын ерөнхий газрын даргыг Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын, мэргэжлийн боловсролын, техникийн боловсролын сургалтын байгууллагын төсвийн төвлөрүүлэн захирагчаар баталсан тул Рашаант сумын Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэгийг улсын төсөвт шилжүүлсэн байна.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзлээ.

Санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчаас нэгдсэн байдлаар боловсруулан мөрдүүлж байна. Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд томоохон өөрчлөлт ороогүй байна. Тайлант онд шинээр Төсвийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлсэн.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Рашаант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн дэргэдэх орон тооны бус дотоод хяналтын нэгжийг Засаг даргын 2020 оны А/33 тоот захирамжаар 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, Төсвийн төвлөрүүлэн захирагчийн дэргэдэх дотоод хяналтын нэгжийн хяналт шалгалт явуулах журмыг сумын Засаг даргын 2022 оны А/65 захирамжаар баталсан байна.

Дотоод хяналтын нэгжийн чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод хяналтын нэгжийн гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод хяналтын нэгжээс шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Рашаант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-д нийцүүлэн нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна гэж үзлээ. Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтад заасан заалтын дагуу иж бүрэн ирүүлсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Рашаант сумын ТТЗ-ийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2005 оны 341 дугаар тушаалаар баталсан “Санхүүгийн нэгтгэсэн тайлан гаргах зааврын”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 7,485.8 сая төгрөгөөр буурсан нь байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	234.1	170.2	-63.9
Авлага	142.7	73.1	-69.6
Бараа материал	523.7	101.2	-422.4
Урт хугацаат хөрөнгө оруулалт	58.5	100.0	41.5
Үндсэн хөрөнгө	8,250.9	1,279.2	-6,971.7
Нийт хөрөнгө	9,209.8	1,723.9	-7,485.9
Өр төлбөр	96.5	0.0	-96.5
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	9,113.4	1,723.9	-7,389.5
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	9,209.8	1,723.9	-7,485.9

Эх сурвалж: Рашаант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө данс өмнөх оноос нэмэгдэж, үндсэн хөрөнгө, бараа материал данс буурсан үзүүлэлттэй байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө данс нь ОНХС-ийн 74.1 сая төгрөг, Хоршоо хөгжүүлэх сангийн 62.2 сая төгрөг, орон нутгийн давсан орлого 33.9 сая төгрөг нийт 170.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Дээрх мөнгөн хөрөнгө нь Төрийн сангийн харилцах дансанд байршиж байна.
- Авлага 69.6 сая төгрөгөөр буурч 73.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Үүнд Хоршоо хөгжүүлсэн сангийн зээлийн авлагын үлдэгдэл 63.9 сая төгрөг, зээлийн хүүгийн авлага 9.2 байна. Үүнээс 2 иргэний 5.7 сая төгрөгийн зээлийн эргэн төлөлт хугацаа хэтэрч шүүхийн шийдвэрээр төлбөрийг барагдуулж байна.
- Бараа материалын дансны үлдэгдэл 422.4 сая төгрөгөөр буурахад "Гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих байгууллагын санхүүгийн тайланг орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлангаас улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд хөрөнгө шилжүүлсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.
- Урт хугацаат хөрөнгө оруулалт 41.5 сая төгрөгөөр өсөж 100.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Энэ нь Хоршоо хөгжүүлэн сангийн 1 жилээс дээш хугацааны дараа төлөгдөх зээлийн үлдэгдэл юм.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 6,971.7 сая төгрөгөөр буурахад "Гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих байгууллагын санхүүгийн тайланг орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлангаас улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд шилжүүлсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.

- Орон нутгийн өмч 7,389.5 сая төгрөгөөр буурахад Гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих байгууллагын санхүүгийн тайланг орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлангаас улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд хөрөнгө шилжүүлсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.

Орлогын данс

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар нийт 1,623.1 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж тайлагнасан байна. Тайлант онд бүрдүүлсэн орлогыг өмнөх онтой харьцуулахад 3,752.8 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №9 Санхүүгийн үр дүнгийн нийт орлого /сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	зөрүү
Татварын орлого	205.9	383.3	177.4
Татварын бус орлого	1,089.7	394.3	-695.4
Тусламж санхүүжилтийн орлого	4,080.2	845.5	-3,234.6
Нийт дүн	5,375.8	1,623.1	-3,752.8

Эх сурвалж: Рашаант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан

Нийт орлогын дүн буурсан шалтгаан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих байгууллагын тайлан улсын төсөвт шилжсэнтэй холбоотой байна.

Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд харьяа байгууллагуудын хоорондын тооцоогоор 1,171.1 сая төгрөгийн орлогын давхардсан гүйлгээг устгаж цэвэр дүнгээр тайлагнасан байна.

Зардлын данс

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангаар 9,028.0 сая төгрөгийн зардал гаргасан байна.

Хүснэгт №10: Санхүүгийн үр дүнгийн нийт зардал /сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	зөрүү	Хувь
Үйл ажиллагааны зардал	4,674.6	1,200.6	-3,474.0	-74.3
Үйл ажиллагааны бус зардал	125.3	7,827.4	7,702.1	
Нийт дүн	4,799.9	9,028.0	4,228.1	88.1

Эх сурвалж: Рашаант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан

Нийт зардлын дүн өссөн нь гүйцэтгэл үр дүнгээр санхүүжих байгууллагын үндсэн хөрөнгө, бараа материалыг шилжүүлэхдээ үр дүнгийн тайланд зардлаар хүлээн зөвшөөрсөнтэй холбоотой байна.

Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд харьяа байгууллагуудын хоорондын тооцоогоор 1,171.1 сая төгрөгийн зарлагын давхардсан гүйлгээг устгаж цэвэр дүнгээр тайлагнасан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны төсвийн төслийг харьяа байгууллагуудын хүрээнд нэгтгэн боловсруулж, дээд шатны төсөв захирагчид хүргүүлсэн байна.

Рашаант сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 26 дугаар тогтоолоор сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 10 хөтөлбөрт зориулан 1,487.5 сая төгрөгийн төсөв баталснаас 1,023.4 сая төгрөгийг урсгал зардалд, 198.3 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, зээл олгоход 168.4 сая төгрөгийг зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 338.7 сая төгрөгийг орон нутгийн орлогоос, 126.8 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас, 852.3 сая төгрөгийг аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг,

107.0 сая төгрөгийг давсан орлого дансны үлдэгдлээс, 62.7 сая төгрөгийг зээлийн эргэн төлөлт болон хүүгийн орлогоос тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд Рашаант сумын ИТХ-ын 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор нийт төсвийг 23.4 сая төгрөгөөр бууруулж тодотгол хийсэн байна.

Гүйцэтгэлээр 1,330.0 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлж, 1,334.3 сая төгрөгийн зардлыг зарцуулж, мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 170.2 сая төгрөг байна. Төсвийн орлого бүрдүүлэлтийг харуулбал:

Сумын төсвийн орлого бүрдүүлэлт.

Рашаант сумын ИТХ-ын 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор Рашаант сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант онд 343.7 сая төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталсан байна. Гүйцэтгэлээр 392.3 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөө 114.1 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт №11. Төвлөрүүлэх орлого

/сая төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Үйл ажиллагааны орлого	18.0	35.9	17.9	199%
Хөрөнгийн орлого	39.0	32.0	(7.0)	82%
Хөрөнгө борлуулсны орлого	0.5	0.5	-	100%
Шууд бус орлого	4.0	3.8	(0.2)	95%
Цалин хөлс шагнал урамшуулал	145.0	169.5	24.5	117%
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(18.3)	(18.3)	-	100%
Бууны албан татвар	3.0	3.2	0.2	107%
Малд ногдуулах албан татвар	47.3	72.9	25.6	154%
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	7.1	4.5	(2.6)	63%
Улсын тэмдэгийн хураамж	4.0	4.2	0.2	105%
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	0.1	0.0	(0.1)	40%
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	10.0	9.8	(0.2)	98%
Газар	10.5	11.7	1.2	111%
Газрын дуудлага худалдаа		1.8	1.8	
Ойн нөөц ашигласны төлбөр	60.7	51.2	(9.5)	84%
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	0.4	0.1	(0.3)	25%
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	0.6	0.3	(0.3)	50%
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	0.1	0.1	0.0	125%
Торгуулийн орлого	7.8	9.1	1.3	117%
Бусад орлого	4.0	-	(4.0)	
ТӨСВИЙН ОРЛОГО	343.7	392.3	48.6	114.1%

Эх сурвалж: Рашаант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга

Рашаант сумын орон нутгийн орлого 181.5 сая төгрөгөөр давж биелэхэд үйл ажиллагааны орлого 17.9 сая төгрөгөөр, цалин хөлс түүнтэй адилтгах орлогын татвар 24.5 сая төгрөгөөр, малын тоо толгойгоос авах татвар 25.6 сая давж биелсэн нь нөлөөлсөн байна.

Орон нутгийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг нэр төрөл бүрээр авч үзвэл 9 төрлийн орлогын нийт 24.1 сая төгрөгийг орлогын төлөвлөгөө тасарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 дэх "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" заалттай нийцэхгүй байна.

Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын талаар: Тайлант онд аймагт төвлөрүүлэх орлогыг 21.0 сая төгрөгөөр төлөвлөж 36.8 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт №12: Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөг/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Аж ахуй нэгжийн орлогын албан татвар	0.5	0.2	-0.3
2	Газрын үл хөдлөх хөрөнгийн татвар		0.02	0.02
3	Авто тээврийн өөрөө явагч хэрэгслийн албан татвар	13.5	17.4	3.9
4	Зам ашигласны төлбөр	3.4	5.4	2
	Нийт дүн	17.3	23	5.7

Эх сурвалж: Рашаант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга

Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө 5.7 сая төгрөгөөр давж биелсэн байна.

Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын талаар: Тайлант онд улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 5.2 сая төгрөгөөр төлөвлөж 4.1 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт №13: Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөг/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	0.7	0.4	-0.3
2	Дотоод бараа үйлчилгээний НӨАТ	3	1.6	-1.4
3	Агаарын бохирдлын төлбөр	1.5	2	0.5
	Нийт дүн	5.2	4.1	-1.1

Эх сурвалж: Рашаант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга.

Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө 1.1 сая төгрөгөөр тасарсан байна.

Тусламж санхүүжилтийн орлогын талаар

Тайлант онд тусламж санхүүжилтийн орлогыг 1,464.2 сая төгрөгөөр төлөвлөж, 1,334.3 сая төгрөг буюу 91.1 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс: Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн хүү болон эргэн төлөлтөөс 62.7 сая төгрөгийг орлогыг оруулахаар төлөвлөж гүйцэтгэлээр 100.0 сая төгрөгийн хүүгийн төлбөр болон зээлийн эргэн төлөлтийн орлогыг төвлөрүүлсэн байна. Хоршоо хөгжүүлэх сангийн эргэн төлөлт өндөр гүйцэтгэлтэй байгаа нь тус сангийн зээлийн мэдээллийг Монгол банкны зээлийн мэдээллийн сантай холбож зээлжих зэрэглэлд хамааруулж эхэлсэнтэй холбоотой байна.

Төсвийн зарлагын талаар:

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 13 хөтөлбөрт зориулан 1,464.1 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,042.7 сая төгрөгийг урсгал зардалд, 253.0 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 168.4 сая төгрөгийг эргэж төлөгдөх төлбөрийг хаасан цэвэр зээлийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Гүйцэтгэлээр урсгал зардалд 1,033.7 сая төгрөгийг, хөрөнгийн зардалд 195.6 сая төгрөгийг, эргэж төлөгдөх цэвэр зээлийн зардалд 100.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,329.3 сая төгрөг буюу 90.8 хувьтай байгаа нь Сангийн яамнаас тэвчиж болох зардлыг санхүүжүүлээгүйтэй холбоотой байна. Төсвийн хэмнэлтийг харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 3.4 сая төгрөг
- Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 1.3 сая төгрөг
- Байр ашиглалттай холбоотой зардал 2.9 сая төгрөг
- Хангамж, бараа материалын зардал 0.2 сая төгрөг
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж 1.1 сая төгрөг
- Урсгал шилжүүлгийн зардал 52.4 сая төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны гүйцэтгэлийн талаар:

ОНХС-ийн санхүүжилтээр 253.1 сая төгрөгийн 10 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 10 төсөл арга хэмжээнд 209.1 сая төгрөгийн зарцуулж мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 51.5 сая төгрөг байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсөв захирагчаас 10.5 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд олсон орлогоос 3.5 сая төгрөг, Засаг даргын нөөц сангаас 2.5 сая төгрөг, нийт 16.5 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Дээрх нэмэлт санхүүжилтийн орлогуудыг удирдамж зориулалтын дагуу зарцуулж ажилласан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

2022 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Рашаант сумын ТТЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Л.Мандахнаран гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Тэгшдэлгэр, дарга тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар хэрэгжүүлсэн.

Рашаант сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 1/80 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 4,674.6 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 70.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 буюу 56.1 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих байгууллагын санхүүгийн тайланг орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлангаас улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд шилжүүлж нийт зардлын хэмжээ буурсан тул материаллаг байдлыг шинэчлэн тогтоов.

Тайлант оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,200.6 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 18.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 80 хувь буюу 14.4 сая төгрөгөөр тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор ТТЗ-ийн харьяа байгууллагуудын Тэргүүн дэд, дэд, орлогч дарга, тээврийн хэрэгсэл, албан тасалгаа, дүрэмт хувцас, албан томилолт, нэг удаагийн мөнгөн тэтгэмж, бусад хангамж, цахим худалдан авалт, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд зөрчилтэй зүйл илрээгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянаж үзэхэд мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж ажилласан бөгөөд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагын худалдан авах ажиллагааны баримт материалыг хянаж үзэхэд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй. Худалдан авах ажиллагаанд харьцуулалтын аргыг ашиглан бага үнийн санал ирүүлсэн байгууллагуудтай гэрээ хийж бараа материалыг худалдан авсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Рашаант сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчилд 3 зөрчилд 3 зөвлөмжийг өгсөн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	-	-	-	-	-
Зөвлөмж	3	-	3	-	100
Нийт дүн	3	-	3	-	100

Өмнөх онд тогтоосон 3 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал хандуулах асуудал гараагүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 29.8 сая төгрөгийн 2 алдаа, зөрчил илэрсэн. Орон нутгийн орлогын төлөвлөгөөний биелэлттэй холбоотой 1, Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлтэй холбоотой 1, нийт 2 зөвлөмж хүргүүлж байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд сумын орон нутгийн ерөнхий орлогын данс болон харьяа 2 байгууллага, орон нутгийн 2 тусгай сангийн нийт 5 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс ЗДТГ-ын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, бусад байгууллага, тусгай сангийн санхүүгийн тайланд аудитын үе шатны ажлын хэсэгчлэн гүйцэтгэсэн.

Аудитад хамрагдсан ЗДТГ-ын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчилтэй асуудал илрээгүй байна.

5.1 Төлбөрийн акт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй байна.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага, хариуцлага тооцох санал хүргүүлээгүй болно.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Орон нутгийн орлогын төлөвлөгөөнөөс 9 нэр төрлийн 24.1 сая төгрөгийн орлогыг дутуу биелүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1.”хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Улс орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг бодитой төлөвлөж, нэр төрлөөр ханган биелүүлж ажиллах.

2. Хугацаа хэтэрсэн зээлийн авлагатай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Хоршоо хөгжүүлсэн сангийн авлагын үлдэгдэл 73.1 сая төгрөг байна. Үүнээс 2 иргэний 5.7 сая төгрөгийн зээлийн эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн байна. Энэ нь Хүнс, хөдөө аж

ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалаар баталсан “Хоршоо хөгжүүлэх сангийн журам”-ын 3.4.11.Сангаас олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөрийг зээлдэгч төлөхгүй тохиолдолд сумын Засаг дарга уг төлбөрийг төлүүлэх арга хэмжээг авч зээлийн дансанд төвлөрүүлнэ гэсэн заалттай нийцэхгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Сум хөгжүүлэх сангийн хугацаа хоцорсон зээл, хүүгийн үлдэгдлийг төвлөрүүлэх талаар үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллага Д шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хоршоо хөгжүүлсэн сангийн авлагын үлдэгдэл 73.1 сая төгрөг байна. Үүнээс 2 иргэний 5.7 сая төгрөгийн зээлийн эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн байна.	1	5.7					1	5.7				
Орон нутгийн орлогын төлөвлөгөөг дутуу биелүүлсэн	1	24.1					1	24.1				
Дүн	2	29.8					2	29.8				
Харьяа байгууллагуудын зөрчил												
Дүн												



ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

БАТАЛГААЖУУЛСАН:

АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

Л.МАНДАХНАРАН ОГНОО: